

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/128/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ СУМЫН ХҮН ЭМНЭЛГИЙН 2021  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: [dum\\_audit@yahoo.com](mailto:dum_audit@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт .....	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт .....	19
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/167  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ  
СУМЫН ХҮН ЭМНЭЛГИЙН ДАРГА  
О.БАЗАРМАА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2021 он/АДБОУС-ын

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>25,426,886.92</u></b>	<b><u>160,782,198.81</u></b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	21,510,555.57
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	21,510,555.57
3121	<b>Төгрөг</b>	00.00	21,510,555.57
31211	Төрийн сангийн харилцах	00.00	16,895,357.38
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	4,615,198.19
33	<b>АВЛАГА</b>	00.00	78,076,500.00
335	<b>Бусад авлага</b>	00.00	78,076,500.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	78,076,500.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	25,426,886.92	61,195,143.24
351	<b>Түүхий эд материал</b>	12,119,381.92	46,184,949.62
35130	Эм боох материал	12,119,381.92	46,184,949.62
354	<b>Хангамжийн материал</b>	13,307,505.00	15,010,193.62
35410	Бичиг хэргийн материал	240,000.00	223,100.00
35420	Аж ахуйн материал	6,813,005.00	8,740,805.00
35440	Түлш, шатах тослох материал	1,000,210.00	1,000,000.00
35460	Хүнсний материал	1,641,590.00	1,856,830.00
35470	Бусад хангамжийн материал	3,612,700.00	3,189,458.62
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>286,244,551.41</u></b>	<b><u>311,211,184.48</u></b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	286,244,551.41	311,211,184.48
392	<b>Биет хөрөнгө</b>	277,596,551.41	302,563,184.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	261,695,947.69	261,695,947.69
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,099,109.76	-19,648,664.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,540,000.00	49,540,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-24,924,000.12	-32,732,000.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	83,560,099.48	101,456,262.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-63,385,576.80	-63,238,486.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,984,155.00	12,266,457.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,774,964.08	-6,776,331.14
393	<b>Биет бус хөрөнгө</b>	8,648,000.00	8,648,000.00
39301	Программ хангамж	850,000.00	850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-850,000.00	-850,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,648,000.00	8,648,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>311,671,438.33</u></b>	<b><u>471,993,383.29</u></b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>311,671,438.33</u></b>	<b><u>471,993,383.29</u></b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	311,671,438.33	471,993,383.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	126,542,458.80	126,542,458.80
51101	Өмч: - төрийн	126,542,458.80	126,542,458.80
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	178,133,094.09	338,455,039.05
51210	Өмнөх үеийн үр дүн	178,133,094.09	178,133,094.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	160,321,944.96

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,995,885.44	6,995,885.44
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>311,671,438.33</b>	<b>471,993,383.29</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>338,547,070.56</b>	<b>721,949,149.12</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>16,766,105.56</b>	<b>145,802,454.12</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	16,766,105.56	145,802,454.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,766,105.56	145,802,454.12
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,600.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,747,505.56	145,802,454.12
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>31,415,265.00</b>	<b>247,914,795.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	290,365,700.00	328,231,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,935,845.00	144,150,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,935,845.00	144,150,755.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	18,801,600.00	19,643,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,801,600.00	19,643,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	7,677,820.00	84,120,840.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,677,820.00	84,120,840.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>345,862,099.86</b>	<b>560,999,704.37</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>345,862,099.86</b>	<b>560,999,704.37</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	340,922,321.45	543,119,561.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	223,987,577.34	256,218,817.45
210101	Үндсэн цалин	156,491,515.76	146,842,088.50
210102	Нэмэгдэл	49,741,106.18	82,739,464.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,579,000.00	3,213,000.00
210104	Урамшуулал	16,175,955.40	23,424,264.53
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,496,117.29	34,988,118.98
210201	Тэтгэврийн даатгал	20,741,851.33	24,861,243.14
210202	Тэтгэмжийн даатгал	2,203,906.06	2,640,310.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,763,124.82	2,111,588.73
210204	Ажилгүйдлийн даатгал	435,203.23	527,822.20
210205	Эрүүл мэндийн даатгал	4,352,031.85	4,847,154.01
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,488,071.60	17,621,207.46
210301	Гэрэл, цахилгаан	3,023,454.00	3,095,598.26
210302	Түлш, халаалт	14,147,617.60	14,315,609.20
210303	Цэвэр, бохир ус	317,000.00	210,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,985,255.00	22,854,438.00
210401	Бичиг хэрэг	1,111,700.00	1,629,350.00
210402	Тээвэр, шатахуун	11,558,890.00	15,559,188.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,423,700.00	1,366,800.00

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	748,400.00	1,691,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,142,565.00	2,257,300.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	350,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	27,460,517.23	176,526,842.35
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,821,450.07	167,287,332.35
210502	Хоол, хүнс	5,639,067.16	9,239,510.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,865,400.00	2,439,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	503,000.00	25,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	710,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,652,400.00	2,414,850.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	642,000.00	259,000.00
210702	Дотоод албан томилолт	642,000.00	259,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	707,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	383,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,290,382.99	32,211,287.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	522,321.00	8,403,029.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,768,061.99	23,808,258.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,939,778.41	17,880,142.54
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	17,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	17,008,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,939,778.41	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,939,778.41	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	872,142.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	872,142.54
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-7,315,029.30</u></b>	<b><u>160,949,444.75</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	627,499.79
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	627,499.79
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-627,499.79
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-7,315,029.30</u></b>	<b><u>160,321,944.96</u></b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>126,542,458.80</b>	<b>6,995,885.44</b>	<b>178,133,094.09</b>	<b>311,671,438.33</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>126,542,458.80</b>	<b>6,995,885.44</b>	<b>178,133,094.09</b>	<b>311,671,438.33</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>126,542,458.80</b>	<b>6,995,885.44</b>	<b>178,133,094.09</b>	<b>311,671,438.33</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	160,321,944.96	160,321,944.96
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>126,542,458.80</b>	<b>6,995,885.44</b>	<b>338,455,039.05</b>	<b>471,993,383.29</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/төгрөгөөр/	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>321,899,565.00</b>	<b>498,070,195.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>118,600.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	118,600.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	118,600.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	118,600.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>321,780,965.00</b>	<b>498,070,195.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	290,365,700.00	328,231,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,935,845.00	144,150,755.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,935,845.00	144,150,755.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	18,801,600.00	19,643,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,801,600.00	19,643,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	7,677,820.00	6,044,340.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,677,820.00	6,044,340.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>320,813,565.00</b>	<b>453,732,839.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>320,813,565.00</b>	<b>453,732,839.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>315,873,786.59</b>	<b>435,852,696.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	224,087,577.34	256,218,817.45
210101	Үндсэн цалин	156,591,415.76	146,842,088.50
210102	Нэмэгдэл	49,741,206.18	82,739,464.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,579,000.00	3,213,000.00
210104	Урамшуулал	16,175,955.40	23,424,264.53
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,496,117.29	34,988,118.98
210201	Тэтгэврийн даатгал	20,741,851.33	24,861,243.14
210202	Тэтгэмжийн даатгал	2,203,906.06	2,640,310.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,763,124.82	2,111,588.73
210204	Ажилгүйдлийн даатгал	435,203.23	527,822.20
210205	Эрүүл мэндийн даатгал	4,352,031.85	4,847,154.01
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,488,071.60	17,621,207.46
210301	Гэрэл, цахилгаан	3,023,454.00	3,095,598.26
210302	Түлш, халаалт	14,147,617.60	14,315,609.20
210303	Цэвэр, бохир ус	317,000.00	210,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,569,420.00	19,333,448.00
210401	Бичиг хэрэг	999,900.00	1,004,050.00
210402	Тээвэр, шатахуун	13,588,120.00	14,604,798.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,481,400.00	1,495,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	2,229,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	16,148,903.36	65,607,646.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,671,423.40	56,599,756.00
210502	Хоол, хүнс	6,477,479.96	9,007,890.00

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,891,520.00	32,298,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	588,200.00	3,549,500.00
210602	Тавилга	00.00	464,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,182,020.00	25,282,000.00
210604	Урсгал засвар	1,121,300.00	3,002,050.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	642,000.00	259,000.00
210702	Дотоод албан томилолт	642,000.00	259,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,706,606.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,999,606.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	383,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	843,571.00	9,526,309.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	843,571.00	9,526,309.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,939,778.41</b>	<b>17,880,142.54</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	17,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	17,008,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,939,778.41	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,939,778.41	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	872,142.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	872,142.54
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,086,000.00</u></b>	<b><u>44,337,355.57</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,086,000.00</b>	<b>22,826,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,086,000.00</b>	<b>22,826,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,086,000.00	22,826,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,086,000.00	22,826,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-1,086,000.00</u></b>	<b><u>-22,826,800.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	21,510,555.57
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	21,510,555.57

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	364,184,200.00	336,172,340.08	28,011,859.92	92.31
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	364,184,200.00	336,172,340.08	28,011,859.92	92.31
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	364,184,200.00	336,172,340.08	28,011,859.92	92.31
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	254,389,900.00	242,525,163.64	11,864,736.36	95.34
210101	Үндсэн цалин	159,142,600.00	146,842,088.50	12,300,511.50	92.27
210102	Нэмэгдэл	66,839,900.00	69,045,810.61	-2,205,910.61	103.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536,000.00	3,213,000.00	1,323,000.00	70.83
210104	Урамшуулал	23,871,400.00	23,424,264.53	447,135.47	98.13
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,342,700.00	33,820,854.98	521,845.02	98.48
210201	Тэтгэврийн даатгал	24,167,200.00	24,067,504.14	99,695.86	99.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,543,900.00	2,546,929.90	-3,029.90	100.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,035,100.00	2,036,883.73	-1,783.73	100.09
210204	Ажилгүйдлийн даатгал	508,700.00	509,145.20	-445.20	100.09
210205	Эрүүл мэндийн даатгал	5,087,800.00	4,660,392.01	427,407.99	91.60
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,757,400.00	17,621,207.46	2,136,192.54	89.19
210301	Гэрэл, цахилгаан	4,774,900.00	3,095,598.26	1,679,301.74	64.83
210302	Түлш, халаалт	14,662,500.00	14,315,609.20	346,890.80	97.63
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	210,000.00	110,000.00	65.63
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,255,000.00	18,604,048.00	3,650,952.00	83.59
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,004,050.00	-4,050.00	100.41
210402	Тээвэр, шатахуун	18,255,000.00	14,604,798.00	3,650,202.00	80.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,495,200.00	4,800.00	99.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	19,389,200.00	15,337,716.00	4,051,484.00	79.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,889,200.00	11,867,746.00	21,454.00	99.82
210502	Хоол, хүнс	7,500,000.00	3,469,970.00	4,030,030.00	46.27
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,250,000.00	6,241,850.00	8,150.00	99.87
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,595,000.00	5,000.00	99.69
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,500,000.00	3,497,000.00	3,000.00	99.91
210604	Урсгал засвар	1,150,000.00	1,149,850.00	150.00	99.99
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,500,000.00	259,000.00	1,241,000.00	17.27
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	259,000.00	1,241,000.00	17.27

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6300000.00	1762500.00	4,537,500.00	27.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,300,000.00	1,762,500.00	4,537,500.00	27.98
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	364,184,200.00	353,939,840.00	10,244,360.00	97.19
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	328,231,900.00	328,231,900.00	00.00	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	328,231,900.00	328,231,900.00	00.00	100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	20,907,400.00	19,643,200.00	1,264,200.00	93.95
132001	Орон нутгийн төсвөөс	20,907,400.00	19,643,200.00	1,264,200.00	93.95
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	15,044,900.00	6,044,340.00	9,000,560.00	40.18
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,044,900.00	6,044,340.00	9,000,560.00	40.18
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	18.00	18.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00	00.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>139,515,156.81</b>	<b>139,515,156.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>139,515,156.81</b>	<b>139,515,156.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	122,507,156.81	122,507,156.81
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	13,693,653.81	13,693,653.81
210102	Нэмэгдэл	13,693,653.81	13,693,653.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,167,264.00	1,167,264.00
210201	Тэтгэврийн даатгал	793,739.00	793,739.00
210202	Тэтгэмжийн даатгал	93,381.00	93,381.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	74,705.00	74,705.00
210204	Ажилгүйдлийн даатгал	18,677.00	18,677.00
210205	Эрүүл мэндийн даатгал	186,762.00	186,762.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	729,400.00	729,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	729,400.00	729,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	50,269,930.00	50,269,930.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,732,010.00	44,732,010.00
210502	Хоол, хүнс	5,537,920.00	5,537,920.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	48,883,100.00	48,883,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,289,900.00	23,289,900.00
210602	Тавилга	1,956,000.00	1,956,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,785,000.00	21,785,000.00
210604	Урсгал засвар	1,852,200.00	1,852,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,763,809.00	7,763,809.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,763,809.00	7,763,809.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	17,008,000.00	17,008,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,008,000.00	17,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,008,000.00	17,008,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	144,130,355.00	144,130,355.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	144,130,355.00	144,130,355.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	144,130,355.00	144,130,355.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	<b>4,615,198.19</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,615,98.19

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дах Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэхийг эрхэм зорилгоо болгон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн даргын 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/02 дугаар тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, дотоод хяналтын ажлын тайланг улирал бүр тайлагнасан.

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлэг нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг.

Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 364,184.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,462.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,097.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### ***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 364,184.2 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 139,515.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 453,732.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### ***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 18,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 26,593.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,808.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 49,402.4 мянган

төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 22,826.8 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 25,914.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 119,226.9 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 117,242.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 200,040.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

#### **Авлага, өглөгийн талаар:**

Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 78,076.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Энэ нь ЭМДЕГ-аас авах санхүүжилтийн авлага байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

#### **Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн дансанд 16,895.4 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансанд 4,615.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансанд үлдэгдэлгүй байна. Бараа материал 61,195.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 310,940.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	21,510.6	21,510.6
Авлага	-	78,076.5	78,076.5
Урьдчилгаа			-
Бараа материал	24,766.0	61,195.1	36,429.2
Үндсэн хөрөнгө	286,663.6	311,211.2	24,547.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>311,429.6</b>	<b>471,993.4</b>	<b>160,563.8</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	311,429.6	471,993.4	160,563.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>311,429.6</b>	<b>471,993.4</b>	<b>160,563.8</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 61,195.1 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 36,429.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 311,211.2 мянган төгрөг болж 24,547.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 471,993.4 мянган төгрөг болж 160,563.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 364,184.2 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 364,184.2 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 364,184.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 328,231.9 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 19,643.2 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 6,064.7 мянган төгрөгийн, нийт 353,939.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 336,172.3 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 16,895.3 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 336,172.3 мянган төгрөг буюу 92.3 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 139,515.2 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 122,507.2 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 17,008.0 мянган төгрөгийг зарцуулж, 4,615.2 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхний үлдэгдлээс 36,429.2 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 өвчний үед шаардлагатай эм бэлдмэл, хамгаалах хувцас хэрэглэл, ариутгалын бодисын бэлэн байдлыг хангах зорилгоор бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлэг нь Коронавируст халдвар /Ковид-19/-ын хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж, 2021 онд коронавирусын батлагдсан тохиолдол 301 гарснаас Аймгийн нэгдсэн эмнэлэгт 21 тохиолдол, сумын Эрүүл мэндийн төвд 280 тохиолдлыг хамруулан эмчилж, хариу арга хэмжээний баг ойрын болон дам хавьтлын судалгааг гарган, давхардсан тоогоор PCR-ийн шинжилгээнд 452 сорьц тээвэрлэж, түргэвчилсэн оношлуураар 905 шинжилгээг хийсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон Коронавируст халдвар /Ковид-19/ -ын тусламж үйлчилгээний санхүүжилтийг хувийн хамгаалах хэрэгсэл, шаардлагатай эм, эмийн нөөц бэлтгэх, ариутгал халдваргүйжүүлэлт, өвчтөний хоол, улаан бүсэд ажилласан эмч, ажилчдын цалин зэрэгт бүрэн зарцуулж, уг үйл ажиллагааг санхүүгийн тайланд толилуулсан.

### **3.8 Аудитын гол асуудал**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 93 нэр төрлийн 47,018.9 мянган төгрөгийн хөрөнгө, 3 нэр төрлийн 850.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хий шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 142 мэдээллийг хугацаандаа, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, 1 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,074.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, 14,664.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 49,169.0 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 241.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,058.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 47,868.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 241.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудитлагдсан тайлантай тулган шалгахад нийт хөрөнгө болон нийт өмчийн дүн 241.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

##### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар 1,058.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд 13 албан хаагчид вакцины урамшуулалт цалин олгохдоо НДШ-ийг суутган тооцолгүй, зөвхөн ХХОАТ-ыг суутган тооцсоны улмаас гарт олгох урамшуулалт цалинг 1,058.3 мянган төгрөгөөр илүү олгосон нь: Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: 1/Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчдаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

##### 4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

##### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 93 нэр төрлийн 47,018.9 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх

## **2. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал**

### **2.1. Илрүүлэлт:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 3 нэр төрлийн 850.0 мянган төгрөгийн үнэ бүхий биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет бус хөрөнгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх

## **3. Шилэн данстай холбоотой асуудал**

### **3.1. Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг үнэн зөв бүрэн гүйцэт мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д / Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баянхангай сумын Хүн эмнэлэг	5	49,169.0	1	241.8	1	1,058.3	-	-	3	47,868.9

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)